



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 356

Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Цахилгаан эрчим хүчинд холбох (Булган аймаг, Бугат сум, Ханжаргалант баг)" барилга угсралтын ажил"-ын хүрээнд бий болсон, нийт 457,250,040.00 (дөрвөн зуун тавин долоон сая хоёр зуун тавин мянга дөч) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу "Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, "Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал В.Адъяа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх, бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомж журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Дэд өртөөний доорх газрыг "Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн нэр дээр баталгаажуулах;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001791

17-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 07 дугаар сарын-н өдрийн
...262... дугаар тогтоолын хавсралт



"ЭРДЭНЭТ БУЛГАНЫ ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Биет хэмжээ	Бүртгэх дүн (төгрөг)
1	10 кВ-ын ЦДАШ	2021	ком	100 кВа чадалтай 10/0.4 кВ ЦДАШ	384,795,370.00
2	Агаарын оруулгатай дэд өртөө АТП	2021	ш	100 кВа чадалтай 10/0.4 кВ ЦДАШ	36,809,046.00
3	0.4 кВ-ын ЦДАШ	2021	ком	100 кВа чадалтай 10/0.4 кВ ЦДАШ	30,456,420.00
4	0.4 кВ-ын 6 айлын тоолуур суурилуулах нэгтгэсэн самбар	2021	ком	100 кВа чадалтай 10/0.4 кВ ЦДАШ	5,189,204.00
					457,250,040.00
Нийт дүн					(дөрвөн зуун тавин долоон сая хоёр зуун тавин мянга дөч)